

## Хэвлэлийн мэдээ

№.14-29

2015 оны 2 дугаар сарын 13-ны өдөр

2 дугаар сарын 16-ны өдөр, Хүүхдийн урлан бүтээх төвд, Монгол, Японы найрамдалт харилцааг харуулсан “Art & Craft ~ Япон улс бол бидний анд” үзэсгэлэнгийн нээлтийн арга хэмжээ болно. Уг үзэсгэлэнгийн ерөнхий зохион байгуулагчаар Хүүхдийн урлан бүтээх төв, хамтран зохион байгуулагчаар Японы Элчин сайдын яам, дэмжигч байгууллагаар Монгол, Японы найрамдлын нийгэмлэг ажиллаж байна.

Үзэсгэлэнд хоёр орны найрамдалт харилцаа болон япон соёлын сэдвээр Хүүхдийн урлан бүтээх төвийн дугуйлангийн сурагчид болон мэргэжлийн уран бүтээлчид болох багш нарын бүтээсэн уран зураг, сийлбэр, хүүхэлдэй гэх мэт 80 орчим бүтээл тавигдана. Түүнчлэн, Японы Элчин сайдын яамнаас үкиё-э зураг болон хина хүүхэлдэй зэрэг 10 бүтээл үзэсгэлэнд тавигдах юм. Сурагч хүүхдүүдийн бүтээл дотроос шилдэг бүтээлийг шалгаруулж Япон улсын Элчин сайдын нэрэмжит шагналыг гардуулах болно.

Энэхүү арга хэмжээг чөлөөтэй сурвалжлах боломжтой тул хэвлэл мэдээллийнхэн Та бүхнийг өргөнөөр сурвалжлахыг урьж байна.

**Нээлтийн арга хэмжээ:** 2 сарын 16 (Даваа) өдөр 15 цагаас

※Бүтээлийн үзэсгэлэн 3 сарын дунд хүртэл үргэлжилнэ

**Хаана:** Хүүхдийн урлан бүтээх төв

**Сурвалжлага хийхэд тавих хориг:** байхгүй

**Лавлах:**

Монгол улсаас Япон улсад суугаа Элчин сайдын яам

Соёл, мэдээллийн хэлтэс